

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН БИЕЛЭЛТ
/2025 оны байдлаар/

Эрүүл мэндийн газар

2025 оны 12 дугаар сарын 30

№	Захирамжийн		Захирамжийн тэргүү	Захирамжийн агуулга	Хугацаа	Биелэлт	Үнэлгээ
	Дугаар	Огноо					
1	A/06	2025.01.06	Үндсэн хөрөнгийн дансны бүртгэл залруулга хийх тухай	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн программ шинэчлэгдэж нэвтрэлтийн нэгдсэн санд бүртгэхтэй холбоотойгоор тавилга эд хогшилын дансанд бүртгэл залруулга хийсүгэй	Тухай бүр	/2025.01.06 Үндсэн хөрөнгийн дансны бүртгэл залруулга хийх тухай Орон нутгийн өмчийн газарт 2024 оны 12 сард байгууллагын зүгээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн программ шинэчлэгдэж нэвтрэлтийн нэгдсэн санд бүртгэхтэй холбоотойгоор тавилга эд хогшилын дансанд бүртгэлтэй 5 нэр төрлийн 1,380,130 төгрөгний хөрөнгийг машин тонтог төхөөрөмжийн хөрөнгийн дансруу, Машин тоног төхөөрөмжөөс 10 нэр төрлийн 11,167,999.94 төгрөгний хөрөнгийг тавилга эд хогшилын дансруу шилжүүлэх санал өгсний дагуу Аймгийн Засаг даргын А/06 тоот захирамжаар хөрөнгийн дансны бүртгэлийн залруулгыг санхүүгийн программд бүрэн хийж гүйцэтгэсэн.	100
2	A/43	2025.01.20	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдын нэрс, зэрэг дэвийг 12 дугаар хавсралтаар баталсугай. Хавсралтад нэр тусгагдсан төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдлийг 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөхийг холбогдох байгууллагуудад зөвшөөрсүгэй.	2025 оны 01 сарын 1-ээс	Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 5 албан хаагчийн зэрэг дэвийг аймгийн Засаг даргын тус захирамжийн дагуу 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн. Үүнд: 1.Хүний нөөцийн төлөвлөлт хангалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн Г.Нарандарийг Тэргүүн зэрэг, Дэс түшмэл 2.Эмийн бодлогын хэрэгжилт чанар аюулгүй байдал эмийн зохистой хэрэглээ эм эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн О.Анхбаярыг Тэргүүн зэрэг, Дэс түшмэл 3.Эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн Г.Итгэлийг Тэргүүн зэрэг, Дэс түшмэл 4. Эрүүл ахуй халдвар хамгааллын улсын байцаагч Б.Будсүрэнийг Гутгаар зэрэг, дэс түшмэл 5.Эрүүл мэндийн боловсрол, сургалт сурталчилгаа, олон нийт хариуцсан ахлах мэргэжилтэн А.Ганчимэгийг Дөтгөөр зэрэг, Дэс түшмэл тус тус нэмэгдүүлсэн.	100

3	A/74	2025.01.28	Үндэсний баг орон нутагт ажиллах хөрөнгө гаргах тухай	Төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Үндэсний багийг Орхон аймагт ажиллуулсугай	Жилийн турш	<p>Тайлант хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Үндэсний баг Орхон аймагт 2 удаа ажиллан ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, зүрх судас, хими эмчилгээ, элэг цөс, тархи мэдрэлийн чиглэлээр нийт 534 иргэнд үзлэг хийж, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах онол, дадлагат сургалтад давхардсан тоогоор 125 хүнийг хамруулан, хамтарсан үзлэг оношилгоо, хагалгаа хийж чадавхжуулсан байна. Үүнд: Үндэсний багийн эмч нартай хамтарч элэгний мэс засал 4, ангио мэдрэлийн ТАСЕ 11 мэс заслыг хийсэн бол бие дааж элэг тайрах мэс засал 1, нойр булчирхайн мэс засал 1, ходоод тайрах мэс заслын-2, хөхний хавдрын мэс заслын 3 тохиолдлыг амжилттай хийгээд байна.</p> <p>Үндэсний багийн эмч нартай хамтарч 14 тархины судасны ангиографийн оношилгоо хийгдсэнээс тархины судасны аневризмийн 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол тус тус шинээр оношлогдсон. Үүнтэй холбоотойгоор орон нутагт нэвтрээгүй зарим мэс заслыг нэвтрүүлэх зорилгоор ШУГТЭ, УХТЭ-т хүсэлт хүргүүлэн хамтарч, гүрээний судасны бөглөрөл, нарийсалд стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг амжилттай хийсэн. Доод мөчдийн их өнгөц венийн судасыг суглаж авах мэс заслын 7 тохиолдлыг бие даан амжилттай хийж байна. Үүнд 2 хүнд элэгний хавдрын судас бөглөх эмчилгээ, 3 хүнд элэгний хавдрын мэс засал, 30 хүнд хөхний үзлэг, оношилгоо хийж, 3 хүнд хөхний мэс засал хийгдсэн. Үндэсний багийн орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардалд орон нутгийн төсвөөс 50,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна. Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр БОЭТ-ийн хавдар болон мэс заслын чиглэлээр нийт 3 эмчийг ХСҮТ-д нарийн мэргэжлийн сургалтад хамруулан хүний нөөцийг чадавхжуулсан байна.</p>	100
---	------	------------	---	--	-------------	--	-----

4	A/126	2025.02.11	Цалин хөлс шинэчлэн тогтоох тухай	Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагын хавсралтад нэр тусгагдсан удирдах ажилтнуудын цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.	2025 оны 01 сарын 1-ээс	Засаг даргын 2025 оны А/126 дугаар захирамжийн хавсралтын дагуу төрийн албаны удирдах албан тушаалтны цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлсэн.Үүнд:Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнхцэцэгийн цалинг 2,049,000 (хоёр сая дөчин есөн мянга) төгрөгөөр тогтоосон.	100
5	A/176	2025.02.28	Хөрөнгө гаргах тухай Бүсийн спорт 5 төрөл	21 аймгийн Эрүүл мэндийн газруудын тамирчдын дунд Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэмцээн 5 төрөлт тэмцээн зохион байгуулж, бие бялдрыг хөгжүүлэх, ур чадавхийг нэмэгдүүлсүгэй	2025 оны эхний хагас жил	Эрүүл мэндийн сайдын нэрэмжит тэмцээнд тамирчдыг сонгон шалгаруулах зорилгоор Эрүүл мэндийн салбарын 5 төрөлт спортын тэмцээнийг 2-р сарын 14-өөс 2-р сарын 16-ны өдрийг хүртэл зохион байгуулж, тус тэмцээнд нийт 338 эрүүл мэндийн ажилтан, албан хаагчид оролцсон. Үүнээс шалгарсан баг тамирчид Дархан хот руу Эрүүл мэндийн сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийн төлөөх бүсийн тэмцээнд амжилттай оролцож, 5 төрөлд оролцох эрхээ авч, Улаанбаатар хотод болсон тэмцээнд амжилттай оролцсон.	100
6	A/250	2025.03.27	Хөрөнгө гаргах тухай цус цусан бүтээгдэхүүн 10 сая	Аймгийн хэмжээнд цус цусан бүтээгдэхүүний хангалтыг нэмэгдүүлэх хөдөлгөөнийг иргэд, аж ахуйн нэгж байгууллага, олон нийтийн дунд өрнүүлсүгэй	Жилийн турш	Орхон аймгийн Засаг даргын А/250 тоот захирамжийн хүрээнд 5 үйл ажиллагаа төлөвлөн биелэлт 97%-тай хэрэгжсэн байна.Тайлант хугацаанд бүхэл цусны 668 донороос 668 нэгж цус цуглуулсны 540 суурин, 128 явуулын хэлбэрээр авч байнгын 498 донороос 498 нэгж цус, шинэ 170 донороос 170 нэгж цус цуглуулсан байна. Нийт 8 байгууллагын 210 хүнд донорын ач холбогдлыг таниулах мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж явуулын хэлбэрээр цус цуглуулалт өмнөх оны мөн үеэс 37 донороор өссөн. Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээнд 688 донор 100% баталгаажиж 3,7% хасагдсан нь өмнөх оны мөн үеэс 0,6 хувиар өссөн. Цусны салбар төвд 10 нэр төрлийн 1448 нэгж цус үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 17 хувиар өссөн үзүүлэлттэй. 2025 оны 11 сарын байдлаар сийвэнгийн 6 сар, цусны О-16, А-3, В-11, АВ-2 нөөцтэй байна.	100

					<p>-“Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 3 зорилт, 13 үйл ажиллагааг төлөвлөн орон нутгийн 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 100% гүйцэтгэж өдөрлөгт нийт 300-аад зочид төлөөлөгчид, хүндэт донор, идэвхтэн донор, байгууллага, иргэд оролцсон.</p> <p>-“Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” аяны хүрээнд донор байгууллагын дундах “Цусаа өгч- итгэл түгээе АСТ тэмцээн”-д 8 байгууллага оролцон мэдлэг, авхаалж самбаагаараа шалгарсан 3 байгууллагын өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшуулсан.</p> <p>-“Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” аяны хүрээнд цус өгөлтийн тоогоороо тэргүүлсэн 2 байгууллага, 10 байнгын донорыг шалгаруулан шагнаж урамшуулсан байна.</p>		
7	A/258	2025.03.31	Хөрөнгө гаргах тухай дэлхийн эмч, сувилагч баяр	Эмч,эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд мэргэжлээрээ бахархах, амжил гарган ажиллаж байгаа эмч ,эмнэлгийн мэргэжилтнийг алдаршуулах, мэргэжлийн ур чадвragы нэмэгдүүлэх ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулсугай	Хугацааны турш	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/258 дугаар захирамжийг үндэслэн Дэлхийн эмч нарын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ЭМГ-ын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар Дэлхийн эмч нарын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийг 2 дугаар, Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах удирдамжийг 3 дугаар, “Эрдэнийн чагнуур” шилдэг эмч шалгаруулах журмыг 4 дүгээр,“Quez niht” эвентийн удирдамжийг 5 дугаар,Эмч нарын хүндэтгэлийн баярын хурлын удирдамжийг 6 дугаар, шаардагдах төсвийг 7 дугаар хавсралтаар тус тус батлан Салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж зангиагүй, чөлөөт ярилцлага, уулзалт өрнүүлж, бие биендээ хүндэтгэл үзүүлэх, амжилт гарган ажиллаж буй эмч нарын хөдөлмөрийг үнэлэх, мэргэжлээрээ бахархах, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн байгууллагуудын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх, Эрүүл мэндийн газар ,Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд ,Жаргалант сумын мэндийн төв ,Эрдэнэт сувилал, клиник,Эрдэнэт Медикал эмнэлэг,Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын 230 гаруй эмч нар оролцож, мэдлэг ур чадвараа дайчлан идэвхтэй</p>	100

					<p>оролцсон. Дэлхийн эмч нарын баярын өдрийг тохиолдуулан АЗДТГ, НБХ-тэй хамтран “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 2025 оны 3-р сарын 22-ны өдөр зохион байгуулж, Эрүүл мэндийн 9 байгууллагын 42 судлаач эмнээгийн мэргэжилтний 21 илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн байна. Эрүүл мэндийн салбарын сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дундах “Эрдэм шинжилгээний бага хурал”-ыг 2025 оны 4-р сарын 16-ны өдөр зохион байгуулж, Эрүүл мэндийн 9 байгууллагын 65 судлаач эмнээгийн мэргэжилтний 15 илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн байна.</p>		
8	A/277	2025.04.09	Ажлын төлөвлөгөө баталж санхүүжилт олгох тухай ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Орхон аймгийн салбар зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасугай	Хугацааны турш	<p>Орхон аймгийн Засаг даргын 2025 оны А/277 тоот захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах Орхон аймгийн салбар зөвлөлөөс 4.5 сая төгрөгийг шийдвэрлүүлэн 2 үйл ажиллагааг зохион байгуулсан.</p> <p>-Дохионы хэлний анхан болон дунд шатны сургалтыг зохион байгуулж 27 эрүүл мэндийн байгууллагын сургалтаар 45 эмч, мэргэжилтэн дохионы хэлний анхан болон дунд шатны мэдлэгийг олж авлаа. Эмч мэргэжилтнүүд анхан шатны сургалтанд хамрагдсанаар тухайн байгууллагаар үйлчлүүлэхээр ирсэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд заавар зөвлөмж өгөх, холбогдох эмч нартай холбон зуучлах зэрэг анхан шатны тусламж үзүүлэхэд саадгүй болж эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг 2%-иар нэмэгдүүлсэн.</p> <p>-Эрхэм нандин сувд ТББ-тай хамтран 2 дах жилдээ “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах үзлэг”-ийг зохион байгуулан ажилласан. Аутизм, тархины саа саажилт, уналт таталт, эпилепси, тархины усжилттай хөгжлийн бэрхшээлтэй 33 хүүхэд үзлэгт хамруулсан. Тус үзлэгээр Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүүхдийн гэмтлийн мэс заслын эмч, ШУГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн 2 эмч, Эх нялхсын эрүүл мэндийн төвийн чих хамар хоолойн, сэргээн засах,</p>	100

						дотор, нүд, уушги, бөөр, мэдрэл, үе мөч, зүрх судас, дотоод шүүрэл, хоол боловсруулах эмгэг зэрэг хүүхдийн нарийн мэргэжлийн 19 эмч нар үзлэгийг явуулж давхардсан тоогоор 172 нэр төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан байна.	
9	A/291	2025.04.10	Хөрөнгө гаргах тухай 49 сая	Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зорилтот бүлгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалсугай	Жилийн турш	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 03/13 дугаар дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/291 дугаар захирамжийг үндэслэн Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн тусламж авах тэгш боломж олгож, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаалаар батлагдсан тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох, “Дэлхийн эрүүл мэндийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сургалт,сурталчилгааны ажлыг зохион байгуулах, “Зөвийг дадал болгоё” шүд угаалгын аварга шалгаруулах тэмцээн, Нийгмийн эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалт, Эрүүл зөв хооллолтын сургалт, өдөрлөг зохион байгуулах, Малчдын эрүүл мэндийн үзлэг, өдөрлөг,Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг,HPV-ийн эсрэг дархлаажуулалтад хамралтыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ болон “Архи, тамхины өдөр”-ийн хүрээнд сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа,Эрүүл мэндийн алхалт,“Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулая” 1 сарын аяныг зохион байгуулах, Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтэрийн болон ахмад настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн, эмчилгээнд хамруулах,Зорилтот бүлгийн даатгалгүй иргэдийн хавдрын эрт илрүүлэг үзлэг оношилгоо зохион байгуулах,Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг үзлэг, гэр бүл төлөвлөлтөд хамруулах	100

						Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагч, ажилчдыг хамруулж, үр дүнг тооцох, Эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах, Цэргийн насны буюу 18-25 насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдлыг дүгнэх, судалгаа хийх, "Өсвөр үеийн эрүүл мэндийн 7 хоног" -сэтгэл зүйн сургалт зохион байгуулах зэрэг зорилтот бүлгийн хүн амын эрүүл мэндийг дэмжих хамгаалах зэрэг 18 төрлийн дээрхи арга хэмжээнд 51620 хүн оролцож, мэдлэг хандлагаа нэмэгдүүлэн, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан байна.	
10	A/292	2025.04.10	Хөрөнгө гаргах тухай 2 сая	Зорилтот бүлгийн иргэдэд сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа зохион байгуулсугай	Тухай бүрт	Засаг даргын 2025 оны A/292 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөр"-ийг Төрийн болон төрийн бус 16 байгууллагатай хамтран "Сэтгэцийн эрүүл мэндийн өдөрлөг"-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборт зохион байгуулж, Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын 11 өртөө ажиллан, 247 иргэнд сэтгэл зүйн чиглэлийн мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч, оношилгоо хийж давхардсан тоогоор 1800 иргэнийг сургалт, мэдээлэлд хамруулан сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгосон.	100
11	A/361	2025.04.30	Бүх нийтээр мод тарих хаврын ажил зохион тухай байгуулах	Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжсүгэй	Жилийн турш	Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ЭМГ-аас 1.100.0 төгрөгөөр 110 ш бургас, 180 ш шар хуайс, БОЭТ-өөс 5.000.0 төгрөгөөр 3000 ш шар хуасыг төмөр замын өртөөний баруун задгай талбайд, 500 ш агч модыг БОЭТ-ийн хашаанд тус тус тарисан байна.	100
12	A/384	2025.05.07	Хөрөнгө гаргах тухай жирэмсэн хөхүүл амин дэм	Зорилтот бүлгийн жирэмсэн эхчүүдийн цус багадаалтыг бууруулсугай	Жилийн турш	Засаг даргын 2025 оны "Хөрөнгө гаргах тухай" A/384 захирамжаар батлагдсан 10 сая төгрөгөөр Эм ханган нийлүүлэх байгууллагуудтай гэрээлэн 90 ширхэгтэй 295 хайрцаг Женли Айрон бэлдмэлийг татан авч, Эрүүл мэндийн газрын даргын A/46 дугаар тушаалаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээр олгож, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Нийгмийн халамж нэн шаардлагатай 535 жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд Женгли Айрон бэлдмэлийг 1-2	100

						сарын хэрэглээг 100% олгож, цус багадалттай–181 (33.8%),эх барихын ужиг дурьдатгалтай –86 (16.1%),эх барихын бус бусад эмгэгтэй –85 (15.9%), нийгмийн халамж нэн шаардлагатай – 111 (20.7%), хөхүүл эх – 72 (13.5%)–д олгон, хэрэглээг цусны давтан шинжилгээгээр хянаж, жирэмсэн эхийн цус багадалтын түвшин өмнөх оны мөн үеэс 0,3%-иар буурсан байна.	
13	A/422	2025.05.15	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдын нэрс, зэрэг дэвийг 12 дугаар хавсралтаар баталсугай. Хавсралтад нэр тусгагдсан төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв түүний нэмэгдлийг 2025 оны 05 сарын 01-ний өдрөөс мөрдөхийг холбогдох байгууллагуудад зөвшөөрсүгэй.	2025 оны 05 сарын 1-ээс	Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 5 албан хаагчийн зэрэг дэвийг аймгийн Засаг даргын тус захирамжийн дагуу 2025 оны 05 сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлсэн.	100
14	A/472	2025.06.05	Аймгийн халдварын сэргийлэх хяналтын салбар зөвлөл"-ийг шинэчлэн байгуулах тухай	Аймгийн хэмжээнд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт хяналтыг мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангах салбар дундын оролцоотой зөвлөл байгуулсугай	Жилийн турш	Орхон аймгийн Засаг даргын А/472 тоот захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй “Аймгийн халдварын сэргийлэх хяналтын салбар зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж 2025 оны үйл ажиллагааг хэлэлцэж, 2025 онд 3 чиглэлээр 13 үйл ажиллагаа төлөвлөн төлөвлөгөөний хэрэгжилт 96% үнэлэгдлээ. 2026 онд салбар хоорондын уялдаа холбоог хангаж “Нэг эрүүл мэнд” үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөлт хийсэн. Орхон аймгийн хэмжээнд ХСХ-йн чиглэлээр дэмжлэгт хяналт 2, аян 2, хэлэлцүүлэг 3, тэмдэглэлт өдөр 3 зохион байгуулж мэргэжил аргагүйгээр ханган ажилласан. Аяны хүрээнд: •Байгууллагын гар угаах, халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн байдал 89%, •ЭМА-ны гар угаах, халдваргүйжүүлэх мэдлэг, дадал	100

						<p>93%,</p> <ul style="list-style-type: none"> •Гарын эрүүл ахуй сахилтын түвшин 60,7%, •Гар угаах, халдваргүйжүүлэх бодис, алчуур, шингэн савангын нөөцийн бэлэн байдал 96% үнэлэгдсэн. <p>Чанар болон сувилахуйн багтай хамтран ажлын байрны онол, дадлага хосолсон сургалтад давхардсан тоогоор 32 байгууллагын 210 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхжсан.</p> <p>-Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/539 тоот тушаалын дагуу 4 төрлөөр ЭТҮХХ-ын сэжигтэй тохиолдлыг 18 эрүүл мэндийн байгууллага нийт 52000 орчим үйлчлүүлэгчдэд тандалт хийснээс БОЭТ ЭТҮХХ-ын сэжигтэй 8 тохиолдлыг бүртгэн мэдээллэж, хариу арга хэмжээ авч ажилласан.</p>	
15	A/253	2025.06.20	Улаанбхан өвчний эсрэг хариу арга хэмжээг злхион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай	<p>2.Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Оюун-Эрдэнэ), өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг Баян-Өндөр сум (Б.Мөнхбаяр), Жаргалант сум (Л.Учрал) нарт үүрэг болгосугай.</p> <p>3. Дархлаажуулалт болон бэлэн байдал, хариу арга хэмжээнд шаардлагатай 15,290,000 (арван таван сая хоёр зуун</p>	Хугацааны турш	<p>Аймгийн Засаг даргын А/523 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд улаанбурхан өвчний эсрэг хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, шаардагдах зардал 15.2 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Ажлын хэсэг 2 удаа хуралдсан. Аймгийн онцгой комиссын хурлаар улаанбурхан өвчний нөхцөл байдлыг хэлэлцэж, БОЭТ-ийн Халдвартын тасагт шаардлагатай амьсгалын аппарат, Срарр аппарат, Монитор зэрэг 6 тоног төхөөрөмжийн санхүүжилтэд 100.0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн. Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 07 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажилласан. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд ажлын өдөр 21 цаг хүртэл, амралтын өдөр 10-18 хүртэл уртасгасан цагаар ажиллаж, дарлаажуулатын 18 явуулын болон байнгын цэгт 90 эмч, эмнэлгийн ажилтан ажилласан. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлыг үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сэдэвт сургалт зохион байгуулж, Онцгой байдлын газар, Тагнуулын газар, Цагдаагийн газрын дарга, асуудал хариуцсан мэргэжилтэн, сум, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай удирдлагын багийн гишүүд 100 хүн хамрагдсан. Улаанбурхан өвчний нийт 68</p>	100

				ерэн мянган) төгрөгийн зардлыг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Галсансайнхувьт)-т зөвшөөрсүгэй.		тохиолдол бүртгэгдсэний 41 /60,3%/ лаборатори, 27 /29,7%/ эмнэлзүйгээр батлагдсан. Сэжигтэй болон батлагдсан тохиолдлын 873 хавьталд тандалт судалгаа хийж, голомтын дархлаажуулалтад хамрагдвал зохих 347/98%/ хүнийг дархлаажуулалтад хамруулсан. Голомтын дархлаажуулалтад 210 хүн тун улаанбурхан, улаануудын эсрэг, 6-8 сартай хүүхдийн дархлаажуулалтад 80 хүн тун, улаанбурханы товлолын дархлаажуулалтад 1500 хүн тун улаанбурхан, гахайн хавдар, улаануудын вакцины нөөц байна. Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад 751 хүүхдийг хамруулж, 1820 хүүхдийн мэдээллийн цахим бүртгэлд нөхөж оруулан, нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2571 хүүхэд нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж 72 хувийг хамруулсан. 2025 оны сараас хойш улаанбурхан өвчин бүртгэгдээгүй байна.	
16	A/550	2025.06.26	Хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах тухай Хүнсний зах	Хууль тогтоомжийн дагуу худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуй нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэх	Хугацааны турш	Аймгийн Засаг даргын А/550 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж, удирдамжийн дагуу Хүлэг худалдааны төвийн Эрдэнэт импекс ХХК-ийн Далхбүрэн ХХК-ийн Хүлэг худалдааны төв, Цагаан алтан хүнс ХХК-ийн ЦАХ маркет худалдааны төв, Даниста-Од ХХК-ийн Даниста худалдааны төвийг тус тус хяналт шалгалтад хамруулж 10.13.1 кодтой Худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуй нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлж,хууль тогтоомжийн хэрэгжилтийн хангалтыг үнэлэхэд Эрдэнэт импекс ХХК, Далхбүрэн ХХК-иуд эрсдэлийн хувь 48%, хууль тогтоомжийн хэрэгжилт 52%, дунд эрсдэлтэй, Цагаан алтан хүнс ХХК эрсдэлийн хувь 39,5%, хууль тогтоомжийн хэрэгжилт 60,5 % дунд эрсдэлтэй, Даниста-Од ХХК эрсдэлийн хувь 15,9%, хууль тогтоомжийн хэрэгжилт 84,5%, бага эрсдэлтэй үнэлэгдэж, Хүлэг худалдааны төвийн түрээслэгч нар болон тэдний хэрэглэж байгаа лангуу тавиур, жин, хутганы бариулаас эрүүл зүйн арчдасны шинжилгээ 60 дээж авч СХЗХ-ийн итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэхэд эрүүлзүйн нян судлалын сорилтын дүнгээр Эрдэнэт импекс ХХК, Далхбүрэн ХХК-ийн мах худалдан борлуулж байгаа түрээслэгч	100

						<p>нар болон тэдний хэрэглэж байгаа лангуу тавиур, жин, хутганы бариулаас 40 арчдасны шинжилгээгээр Enterobacter, 10 арчдасны шинжилгээгээр E.Coli илэрч гэдэсний бүлгийн нянгийн бохирдолтой байгаа нь Эд зүйлсийн гадаргуугаас арчдас авч шинжилгээ хийх арга MNS 6410:2018 стандартын шаардлагыг хангахгүй, Хүнсний тухай хуулийн 10.1.1,12.1,15.1.3 дахь заалтыг, ХБАБХТухай хуулийн 11.1.1 заалт, Эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангахгүй, хүнсний аюулгүй байдал ноцтой зөрчигдөж байгаа учир ажлын хэсэгт Хүлэг худалдааны төвийн үйл ажиллагааг яаралтай зогсоох санал оруулсан. Хүлэг худалдааны төв нь мэргэжлийн эрүүл ахуйч эмчгүй, эрүүл ахуйн дадлыг ажлын байран дээр мөрдүүлж хэвшээгүй зэрэг зөрчил дутагдалтай давтан илэрсэн тул үйл ажиллагааг 2 өдөр зогсоож ажлын байранд болон хэрэглэгдэхүүнийг халдваргүйжүүлэх арга хэмжээг авахуулж давтан шинжилгээ хийлгэсэн. Даниста болон ЦАХ маркет худалдааны төвд улсын байцаагчийн нэгдсэн хугацаатай албан шаардлага хүргүүлж биелэлтийг газар дээр нь шалгахад эрүүл ахуйн шаардлага хангуулах 17 заалтаас 15 заалт хэрэгжиж биелэлт 88,2% байна. Ажлын хэсгээс Хүлэг худалдааны төвийг нүүлгэн шилжүүлэх асуудлыг Засаг даргын зөвлөлд танилцуулсан.</p>	
17	A/600	2025.07.07	Мөнгөн урамшуулал олгох тухай	Аймгийн Засаг даргатай Засаг даргын дэргэдэх хэлтэс, газар, албадын болон сумдын Засаг дарга нарын 2025 онд байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээний дүнг үндэслэн олгох мөнгөн урамшууллыг	Хугацааны турш	<p>Аймгийн Засаг даргын 2025 оны А/600 дугаар захирамжийг үндэслэн 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жил буюу 1, 2-р улирлын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 85.1 хувиар үнэлэгдэж, үндсэн цалингийн 100 хувьтай тэнцэх 2.049.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг тооцож олгосон.</p>	100

				хавсралтаар баталсугай.			
18	A/637	2025.08.05	Хөрөнгө гаргах тухай ISO	Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг нэвтрүүлсүгэй	Жилийн турш	ЭМГ-аас 2025 онд Олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг 5 ӨЭМТ-д нэвтрүүлэхээр 18.650.0 төгрөгийг орон нутгаас шийдвэрлүүлж, Ворд стандарт консалтинг академи компанитай гэрээ байгуулан зөвлөх үйлчилгээнд хамруулж, Мон серфт ХХК-аас баталгаажуулалтын аудитыг хийлгэж гэрчилгээг гардан авлаа. БОЭТ-ийн 40 албан хаагч, хувийн хэвшлийн эмийн сангийн төлөөлөлүүдэд стандартын танилцуулах сургалтыг хийлээ. Дотоод аудитор бэлтгэх сургалтад нийт 1.350.0 төгрөгийг БОЭТ-оос 3 чанарын багийн ажилтанд зарцуулж, ӨЭМТ-өөс 10 эмч, сувилагч, хувийн хэвшлийн эмнэлгээс 1 ажилтан нийт 13 албан хаагчийг дотоод аудиторын гэрчилгээг гардан авлаа. Нийт 20.0 сая төгрөгийг зарцуулсан.	100
19	A/763	202509.22.	Хөрөнгө гаргах тухай Эрүүл шүд сая 10	Шүдний өвчлөлийг бууруулах, дахин өвчлөхөөс сэргийлэх аргыг заах, мэдлэг, дадалыг олгох зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нүүр амны эрүүл ахуйч сургагч багшаар бэлтгэх төвийн сургалтад хамруулсугай	Жилийн турш	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд арга хэмжээг хэрэгжүүлэх” тухай Эрүүл мэндийн сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын хамтарсан “Эрүүл шүд арга, хэмжээ” 2024-2027 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд шүдний өвчлөлийг бууруулах, дахин өвчлөхөөс сэргийлэх аргыг заах, мэдлэг, дадалыг олгох зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг нүүр амны эрүүл ахуйч сургагч багшаар бэлтгэх, онол, гардан үйлдлийг хослуулсан сургалтыг Аймгийн ЗДТГ, ИТХ, Мишээл хүүхэд сан ТББ, Эрүүл мэндийн газар, Шүд холбоотой хамтран 2025 оны 10 дугаар сараас 08-наас 10 хүртэл нийт 85 сургуулийн болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, сувилагч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, шүдний эмч, эрүүл ахуйч нарыг хамруулж багц хэрэглэгдэхүүн 85 ширхэгийг бэлтгэн тарааж, гэрчилгээг гардуулан өгсөн. Нийт 10.0 сая төгрөгийг 8 багшийн зардал, үйл ажиллагааны зардал болон 85 хүнд багц хэрэглэгдэхүүний зардалд тус тус зарцуулсан.	100

20	779/A	2025.09.24	Ээлжит цэрэг татлага, халалтыг зохион байгуулах тухай	Цэрэг татлагын үзлэг зохион байгуулах бэлтгэл хангасугай	Жилийн турш	Орон нутагт зохион байгуулагдсан ээлжит цэрэг татлагаар үзлэгт орох цэргийн насны залуучуудыг үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай БОЭТ-ийн 6 нарийн мэргэжлийн эмч нарын ажлын зохицуулалтыг хийж, бэлэн байдлыг ханган ажиллуулсан. Иргэний цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд 10 багийн 178 цэргийн насны залуучуудуудыг эрүүл мэндийн үзлэг хяналтад хамруулж, эрүүл 48,3%, өвчтэй илэрсэн 51,7%-ийг идэвхтэй хяналтад авсан байна.Үзлэгээр 6 төрлийн шинжилгээ зүрхний бичлэг, шээс, ДОХ, тэмбүү, В/С вирус, рентген зураг,11 төрлийн нарийн мэргэжлийн үзлэг хийсэн.	100
21	A/819	2025.10.07	Хөрөнгө гаргах тухай ПАП	2. Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга(Б.Оюун-Эрдэнэ), мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар(Ц.Мөнхцэцэг), үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулж, оролцоог хангаж ажиллахыг Боловсролын газар(О.Ариунгэрэлт)-нарт тус тус даалгасугай. 3.Дархлаажуулалтын үйл ажиллагаанд	11 сарын 30	Ажлын хэсэг 1 удаа хуралдаж салбаруудад үүрэг чиглэл өгсөн. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг даалгаврыг засаг даргын 2025 оны 11 сарын 04-ны өдрийн 01 дугаар албан даалгавраар хүргүүлсэн. Эрүүл мэндийн газрын даргын А/96 дугаар тушаалаар эцэг, эх, асран хамгаалагч нарт вакцины үр, дүн ач холбогдлыг таниулах ухаалга, нөлөөллийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж ажиллалаа. Товлолын дагуу 2013 онд төрсөн 2417 хүүхдээс 1221(50.6%), 2014 онд төрсөн 2341 хүүхдээс 1550(66.4%), нийт хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 58,2% хүрч, 27,4% нэмэгдсэн байна. Дархлаажуулалтын үйл ажиллагаанд оролцож буй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах 3 удаагийн сургалт зохион байгуулж, сургуулийн эмч, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, нийгмийн эрүүл мэндийн төвийн ажилтан, вакцинолог 60 хүнийг хамруулсан. Мөн ажлын бус цагаар эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээлэл өгөх зөвлөгч бэлтгэх, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдийг сургуулиудад арга зүйн зөвлөмж өгөх чадавхжуулах сургалтад хамруулж, 25 хүн хамрагдсан. Ухуулга, нөлөөллийн арга хэмжээг танхимаар, бүлгээр болон ганцаарчилсан хэлбэрээр	100

				шаардагдах 8,555,000 (найман сая таван зуун тавин таван мянган) төгрөгийг Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, дархлаажуулалтыг хамралтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааны зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /Л.Галсансайнхувьт/-т зөвшөөрсүгэй.		уулзалт, сургалт, зөвлөгөө зохион байгуулж, сургууль бүрд “Дархлаажуулалтын өдөрлөг” зохион байгуулж ажилласан. Тус арга хэмжээнд сум, өрхийн эрүүл мэндийн 9 төв, ерөнхий боловсролын 23 сургууль хамтран ажиллаж, 4,500 гаруй сурагч, 2,700 гаруй эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөлөл хамрагдсан. Мөн сурагч болон эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллөөс үе тэнгийн сургагч 200 багш бэлтгэж, сургууль бүр дээр дархлаажуулалтын үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. Цахим нөлөөллийн хүрээнд ХПВ-ийн тухай, илрэх шинж тэмдэг, үүсэх шалтгаан, дархлаажуулалтын ач холбогдол, зөвлөмж зэрэг нийт 15 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсаар зурган болон видео хэлбэрээр бэлтгэн иргэд, олон нийтэд түгээв. Тус мэдээлэл давхардсан тоогоор 63,742 иргэнд хүрч, 221 байгууллага, иргэд өөрийн цахим хуудсаар хуваалцсан байна.	
22	A/820	2025.10.07	Хөрөнгө гаргах тухай	1.Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд аймгийн эрүүл мэндийн салбарт хэрэгжихээр тусгагдсан үйл ажиллагаануудыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай 2.Нийт зардалд шаардагдах 150,0 сая төгрөгийг төсөл хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын	Хугацааны турш	“Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” арга хэмжээний хүрээнд 2025 онд эрүүл мэндийн салбар 2 зорилт, 6 чиглэл, 7 үйл ажиллагаа, 15 арга хэмжээг төлөвлөн 95% гүйцэтгэлтэй ажилласан. Хүн амын бүлгүүдийн хөгжлийг хангах чиглэлээр : -Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг 16 удаа зохион байгуулж, 552 охидыг хэвлийн эход хамруулан, 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан. Ээлжит цэрэг татлагын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог 12 чиглэлээр зохион байгуулан ажиллалаа. Үзлэгт нийт 499 залуучууд хамрагдсан. Үзлэгийн дүнд 817 өвчлөл илэрч, 129 залуучууд эрүүл мэндийн заалтаар цэргийн албанд татагдахаас хасагдсан байна. -Хүчний байгууллагуудын эрэгтэй ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 7 чиглэлээр зохион байгуулж, нийт 300 эрэгтэй ажилтан хамрагдаж чих, нүдний өвчлөл, зүрхний хэм алдалт, түрүү булчирхайн үрэвсэлт өвчнүүд илэрсэнийг яхналтад авсан байна.Тайлант хугацаанд иргэдийг	100

				газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /Л.Галсансайнхувьт/-т зөвшөөрсүгэй.		<p>хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх, эрүүл илүүдэл жингүй байх чиглэлээр нийт 9 удаагийн өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, 3850 иргэнийг хамруулсан.</p> <p>-Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 53,6% буюу 23,4%, Улаанбурханы нөхөн дархлаажуулалтанд 745 хүүхдийг хамруулж, 1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж оруулан, нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2519 хүүхэд нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж, хамралт 70% буюу 38% тус тус нэмэгдсэн.</p> <p>-Нярайн түнхний дутуу хөгжлийн эрт илрүүлгийн эхо оношилгоонд 1605 буюу 99.6%-ийг хамруулж, давтан оношилгоонд 1470 нярай хамрагдан, түнхний дутуу хөгжилтэй нярай илрээгү байна.</p> <p>-Нярайн төрөлхийн дүлийрэл, сонсол бууралтын эрт илрүүлэгт 1111 нярай хамрагдсан ба төрсөн нярайн 69%-ийг хамруулж, үүнээс 65 (5.8%) нярайд давтан үзлэг хийж, чих хамар хоолойн эмчид 2 нярайг илгээж, хяналтад авсан.</p> <p>-Нярайн скрининг бодисын солилцооны 5 төрлийн эмгэгийн эрт илрүүлэгт 1180 нярайг хамруулсан ба төрсөн нярайн 73.3% хамрагдсан. Өсгийн хатгаасан цусны толбоны шинжилгээнд 38(3,2%) нярайг хамруулж, өөрчлөлт илэрсэн 1 нярайг хяналтад авсан.</p>	
23	A/864	2025.10.20	Үндэсний баг орон нутагт лах хөрөнгө ажил гаргах тухай	Эмнэлгийн тусламж үйлчилгээн дэх төвлөрлийг сааруулах хүрээнд Үндэсний багийг орон нутагт ажиллуулах	Жилийн турш	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээн дэх төвлөрлийг сааруулах хүрээнд ЭМЯ-тай хамтран орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон аймагт төрөлжсөн мэргэшлийн эрүүл мэндийн байгууллагын хэрэгцээтэй байгаа тусламж үйлчилгээг нутагшуулах, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хүлээгдлийг бууруулах, эмч мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор Улсын II, III-р эмнэлгийн Харвалт шигдээсийн төв, Хавдар судлалын үндэсний төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн Үндэсний баг 2025 онд 678 хүнд үзлэг оношилгоо, 82 хүнд хагалгааг орон нутгийн мэргэжлийн</p>	100

						эмч,эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран хийж, ур чадварыг нэмэгдүүлсэн байна.	
24	A/974	2025.11.25	Хөрөнгө гаргах тухай	1.Аймгийн хэмжээнд хүн амын дунд амьсгалын замын халдварт өвчний тархалт нэмэгдэн, Алаг цоог дэгдэлтийн түвшинд хүрч, эмнэлгийн тусламж үйлчилгээний ачаалал ихэссэн тул томуу, томуу тест өвчний үүсгэгч илрүүлэх шаардлагатай Полимеразийн гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээний оношлуурын зардалд шаардагдах 14,710,000 (Арван дөрвөн сая, долоон зуун арван мянган) төгрөгийг Төсөл хөтөлбөрийн “Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед орон нутгийн түвшинд дэмжлэг үзүүлэх зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Галсансайнхувьт)-т	Хугацааны турш	Орон нутгийн санхүүжилтээр 2024/2025 онд өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2000 ш түргэвчилсэн тест, БОЭТ-д 3 төрлийн тус бүр 250 ш ПГУ шинжилгээний оношлуураар хангасан. 2025-2026 онд Засгийн газрын 2025 оны 11 сарын 24-ны өдрийн 28 дугаар хуралдаанаас гарсан Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн вирус судлалын салбар лабораторийг вирусийн геномын дарааллыг тогтоох болон үүсгэгч илрүүлэх урвалж, оношлуураар хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулахыг шийдвэрийн хүрээнд 7 төрлийн 800 оношлуур, 5 төрлийн 1360 дагалдах хэрэгслийн худалдан авах гэрээ хийж, санхүүжилтийг шилжүүлсэн. Гэрээний дагуу оношлуур 21 хоногийн дотор нийлүүлэгдэнэ. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вирус судлалын лабораторид нийт 78 сорьц шинжилсний 62,8 хувьд вирус илэрч, 46/93,8%/ H3N2, A3C вирус 3/6,1%/ илэрсэн байна.	70

				зөвшөөрсүгэй.			
25	A/975	2025.11.25	Хөрөнгө гаргах тухай 6.445	<p>1.Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Оюун-Эрдэнэ), мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулж, оролцоог хангаж ажиллахыг Боловсролын газар (Д.Эрдэнэжаргал) нарт тус тус даалгасугай.</p> <p>2.Дархлаажуулалтын үйл ажиллагаанд шаардагдах 6,445,000 (Зургаан сая, дөрвөн зуун дөчин таван мянган) төгрөгийг “Заавал хийх товлолын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, хамралтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах” зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн</p>	Хугацааны турш	<p>Эрүүл мэндийн газрын даргын А/105 дугаар тушаалаар дараахь арга хэмжээг зохион байгуулж ажилласан.Үүнд:</p> <p>-Ерөнхий боловсролын сургууль бүрээс 2 нийт 40 сурагчийг “Дархлаажуулалтын сургагч багш” үе тэнгийн сургагч багшаар бэлтгэсэн.</p> <p>-Өрхийн эрүүл мэндийн төв, сургуулиуд хамтран дархлаажуулалтын ач, холбогдлыг таниулах өдөрлөг 23 сургуульд зохион байгуулж, 20 ш зурагт баннер, 2500 ш гарын авлага хэвлэж түгээсэн.</p> <p>-Жирэмсэн болон 0-2 насны хүүхэдтэй ээжүүдэд товлолын дархлаажуулалтын ач холбогдлыг таниулах сургалт сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулж, 200 ээж хамрагдсан.</p> <p>- Ерөнхий боловсролын сургуулийн дархлаажуулалтын хамралтын судалгааг шалгаж, дархлаажуулалтаас хоцорсон болон бүртгэл дутуу 1077 хүүхдийн нөхөн шивэх, дархлаажуулах арга хэмжээг авч ажилласан.</p> <p>-Дээрх арга хэмжээний үр сургуулийн насны хүүхдэд товлолоор хийгдэх сахуу татран, улаанбурхан, гахайн хавдар, улаанууд, хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралт 5-10% нэмэгдэж, 2 хүртэл насны хүүхдийн дархлаажуулалтын хамралт 99,8%-д хүрсэн байна.</p>	100

				сангийн хэлтэс /Л.Галсансайнхувьт/-т зөвшөөрсүгэй.			
26	A/978	2025.11.25	Хөрөнгө гаргах тухай ТТӨ	<p>2. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг зохион байгуулан, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), хүүхдийн байгууллагад халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Боловсролын газар (Д.Эрдэнэжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.</p> <p>3. Үйл ажиллагаанд шаардагдах 25,000,000 (Хорин таван сая) төгрөгийг “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед зорилтот бүлгийн хүүхдүүдийг амин дэмжүүлэх, нийтийг хамарсан дэгдэлт гарсан үед өрхийн эрүүл мэндийн төвийг илүү цагаар ажиллуулсан нэмэгдэл</p>	Хугацааны турш	<p>Аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчин томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээгээр аймгийн хэмжээний дэгдэлтын түвшинд 3 долоо хоног хүрч, 52 дугаар долоо хоногийн байдлаар алаг цоог дэгдэлтийн түвшинд байна.Өвчлөлийн тархалтын түвшинд тохирсон хариу арга хэмжээний хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 2 долоо хоног уртасгасан цагаар болон амралтын өдөр ажилласан. Мөн 6 долоо хоногийн турш эрсдэлтийн бүлгийг иргэдийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлж байна.</p> <p>Тус хугацаанд 114 эмч эмнэлгийн ажилтан илүү цагаар ажиллаж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд нийт 12350 хүнд гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс 0-1 насны хүүхэд 2330 (19%), 1-5 хүртэлх насны хүүхэд 2576 (21%), ахмад – 2075 (17%), жирэмсэн – 516 (4%), хөгжлийн бэрхшээлтэй иргэд – 438 (4%) эзэлж байна. Үүнээс цахимаар – 2528 (20%), утсаар – 4980 (40%), гэрээр – 4842 (39%) тандалт хийн, зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд уртасгасан цагаар 4 долоо хоног ажиллан 552 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 342 (62%) байв. Амбулаториор үзүүлсэн томуу, томуу төст өвчтэй 272 хүүхдэд өдрийн эмчилгээний багц олгосон, утлага аппаратад 336 хүүхэд, доргионт массаж 342, зөгийн балай татлагад 290 хүүхэд хамрагдсан байна.</p> <p>Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр дэмжлэгт хяналт хийж, ажлын байранд мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.</p>	100

				хөлсийг тооцож олгох” зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс /Л.Галсансайнхувьт/-т зөвшөөрсүгэй.			
27	A/1005	2025.11.27	Хөрөнгө гаргах тухай	Өсвөр үеийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах, ЭМБ-уудын антибиотикийн хэрэглээг хянах, судалгаа хийсүгэй	Хугацааны турш	Өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих, чиг баримжаа олгох сургалтыг эх, барих эмэгтэйчүүдийн эмч нартай хамтран политехник коллеж, Ерөнхий боловсролын 6 сургуульд 7 удаа зохион байгуулан 112 ахлах, дунд ангийн сурагч, багш нарыг хамруулж “Өсвөр насны охид хөвгүүдийн нөхөн үржихүйн онцлог, эрүүл ахуй чиглэлээр эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгож, тэдний мэдлэг хандлагыг сайжруулж, багш, сурагчдын ангидаа нөлөөлөх оролцоог нэмэгдүүлсэн. Өсвөр үеийнхэн, эцэг, эх асран хамгаалагчдад эрүүл мэндийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх 4 цуврал контентийг бэлтгэн түгээж олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. Политехник коллеж, Ерөнхий боловсролын 23 сургуулийн багш, эмч, нийгмийн ажилтан нарт өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулж, 48 эмч, багш, нийгмийн ажилтныг хамруулан чадавхжуулсан. Тус захирамжийн дагуу антибиотик хэрэглээнд үнэлгээ хийх, судалгаа хийх зорилгоор БОЭТ-ийн 7 тасаг, хувийн хэвшлийн 9 ор бүхий эмнэлэгт 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналт хийхээр удирдамж батлуулсан. Удирдамжийн хүрээнд судалгаа хийх арга зүй, судалгаа авах маягыг боловсруулан бэлтгэл ажлыг ханган, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу судалгаа авч, хяналт хийн мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100%-тай байна.	70
28	A/1027	2025.11.28	Хөрөнгө гаргах тухай Онцгой 112.100	Томуугийн хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлэх,	Хугацааны турш	Аймгийн хэмжээнд томуугийн харуулдан тандалтыг амбулатори болон стационарт,лабораторит суурилсан 3 хэлбэрээр хийж байна. Томуу, томуу төст өвчний	100

				харуулдан тандалтын бүртгэл мэдээллийн чанарыг сайжруулах		тандалтын мэдээг 10 байгууллагын 25 нэгжээс цуглуулж, нэгтгэн хариу арга хэмжээг авч ажилладаг. Энэ хүрээнд томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх, тандалтын мэдээг тасралтгүй, шуурхай цуглуулах зорилгоор 2 төрлийн зөөврийн компьютер 3ш, суурин компьютер ш, принтер 1ш худалдан авч, салбаруудад хуваарилан мэдээллийн урсгалыг сайжруулаад байна.	
Хэрэгжилтийн дундаж хувь- 97,8 %							

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ